

ХОНХОР ТОСГОНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ
ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН 2025 ОНЫ 3 ДУГААР УЛИРАЛЫН ТАЙЛАН

2025 оны 09 дүгээр сарын 25

Улаанбаатар хот

Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт:

Өргөдөл, талархал, гомдлын төрөл

Д/д	Төрөл	Бодит тоо	Нийт өргөдөл, гомдолд эзлэх хувь
1	Нийт :	5	100%
1	Талархал	2	40%
2	Өргөдөл	0	
3	Гомдол	3	60%
4	Хүсэлт	0	
5	Бусад	0	

Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт

Байгууллага нэр	Өргөдөл гомдлын тоо	Үүнээс					
		Бичгээр	ЗГ-ын 11-11 төвөөр	1800-1200 утсаар	Утсаар	Биечлэн	Бусад
Хонхор тосгоны эрүүл мэндийн төв	Өргөдөл						
	Гомдол		2			1	
	Талархал		2				
	Хүсэлт						

Өргөдөл, талархал, гомдлын агуулга

д/д	Төрөл	Өргөдөл гомдлын нийт тоо	Нийт өргөдөлд эзлэх хувь
1.	Эмчилгээ, үйлчилгээний чанар, хүртээмжтэй холбоотой	2	67%
2.	Эмч ажилчдын мэргэжлийн чадвар, харилцаа, хандлага, ёс зүйтэй холбоотой	1	33%
3.	Ажилтнуудын нийгмийн асуудалтай холбоотой	0	
4.	Бусад	0	

Хонхор тосгоны эрүүл мэндийн төвд 2025 оны 3 дугаар улиралд Засгийн газрын харьяа иргэд олон нийттэй харилцах 11-11 төвөөс 2 талархал, 2 гомдол, байгууллагын санал, гомдол хүлээн авах хайрцагаар 1 гомдол ирсэн байна.

Тус эрүүл мэндийн төвийн 3 дугаар улиралын тайлант хугацаанд иргэд олон нийттэй харилцах 11-11 төвөөс 2 талархал ирсэн нь мэргэжлийн ур чадвар, түргэн шуурхай найрсаг үйлчилгээ, иргэдийнхээ эрүүл мэндийг сахин хамгаалах их үйлсэд сэтгэл зүрхээ зориулан ажилладаг тухай уламжилсан байна. Ирсэн 3 гомдлын шийдвэрлэлтийг товч дурдвал: Үүнд эмчилгээ, үйлчилгээний чанар, хүртээмжтэй холбоотой 2 гомдол, харилцаа, хандлага, ёс зүйтэй холбоотой 1 гомдол ирсэн байна.

1. Дархлаажуулалтын сувилагч Я.Туяацэцэгт 0-16 настай хүүхдийн дархлаажуулалтын вакцины нөхөн шивэлттэй холбоотой гомдол байсан. Гомдлын дагуу ЭМТҮЧАБ-ийн баг хэлэлцүүлэг хийж ЭМТҮЧАБ-ийн багийн ахлагч Б.Бямбасүрэн багийн гишүүд болон дархлаажуулалтын сувилагч Я.Туяацэцэг, Ц.Даваасүрэн нар оролцож иргэний гаргасан гомдлын талаар асууж тодруулан гомдол гаргасан иргэнтэй уулзан гомдлыг шийдвэрлэсэн.

2. ЯТТ-ын их эмч Д.Наянжин нь ЯТТ-аар ирсэн үйлчлүүлэгчид булчин тарилга хийсний улмаар иргэнийг 14 хоногоос дээш хугацаагаар хөдөлмөрийн чадвар алдалтанд оруулсан талаар иргэний гомдол ирсэн. Уг гомдол одоогоор НЭМГ-ийн мэргэжилийн хяналтын мэргэжилтэн болон прокурорт шилжигдэн хэрэг шийдвэрлэлийн хугацаанд явж байна. Уг тохиолдолтой холбогдуулан удирдлагын баг хуралдан ЭМТҮЧАБ, халдвар хяналт, дотоод хяналтын багуудад эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой ахин ийм алдаа гаргахгүй байх, үйл ажиллагаагаа сайжруулах албан даалгавар өгсөн. Их эмч Д.Наянжинд ээлжин амралт өгч, асуудлыг шийдвэрлэх хугацаанд ажлаас чөлөөлөхөөр шийдвэрлэсэн болно.

3. Амбулаторийн эмч С.Баасанжавд иргэн Г.Цэрэнбадамаас эмч мэргэжилтний харилцаа, хандлага, ёс зүйтэй холбоотой гомдол байгууллагын даргат ирсэн. Уг гомдлыг Ёс зүйн багийн ахлагч Б.Гоомаралд танилцуулан гомдлыг хүлээлгэн өгч ёс зүйн багийн хурлаар оруулсан. Хурлын шийдвэрээр их эмч С.Баасанжавд байгууллагын дотоод журмын дагуу нээлттэй сануулах арга хэмжээ авах саналыг гаргасан. ЭМТ-ийн дарга болон ёс зүйн баг хуралдан нээлттэй сануулах арга хэмжээ авахаар шийдвэрлэв.

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ХОНХОР ТОСГОНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА *В.Өм* Ө.ӨЛЗИЙПАГАМ

ТАЙЛАН БИЧСЭН:

ХҮНИЙ НӨӨЦ, БИЧИГ ХЭРЭГ

Ал

